

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

3-15

**1.Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар
болон Монгол Улсын Засгийн газар хоорондын
“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-
ийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас
2026.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/**

3-15

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороодын
06 дугаар сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 56 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 51.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 09 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батбаяр, Н.Батсүмбэрэл, Х.Болормаа, Д.Бум-Очир, Г.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Г.Хосбаяр, Д.Үүрийнтуяа, Ө.Шижир, С.Эрдэнэболд;
Чөлөөтэй: Р.Батболд, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, П.Пүрэвдаваа, Б.Түвшин, Л.Оюун-Эрдэнэ, Да.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Р.Эрдэнэбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Ж.Ганбаатар, П.Сайнзориг;
Тасалсан: Б.Батбаатар.

Нэг.Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2026.05.25-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Соёл, урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Наранцэцэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн У.Марал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Отгонбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Анхтуяа, Хавдар судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал Ц.Батболд, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал Ж.Отгонбаатар, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Т.Нарантуяа, Цэргийн төв эмнэлгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Дуурь бүжгийн эрдмийн театрын Захиргааны хэлтсийн дарга М.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Шишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, Д.Энхтүвшин, Д.Ганбат, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал Ж.Отгонбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, М.Бадамсүрэн, Л.Мөнхбаясгалан нар үг хэлэв.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар танилцуулав.

Н.Наранбаатар: Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 14
Бүгд: 32
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 52 минут үргэлжилж, 56 гишүүнээс 32 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
15 цаг 09 минут.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Н.Наранбаатар: Байнгын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хороодын хамтарсан хуралдааны ирц бүрдсэн тул 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар, Энхтайваны Бат-Амгалан, Батбаярын Жаргалан, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Жадамбын Энхбаяр, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Булгантуяа, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар, Чинбаатарын Анар, Энхбатын Болормаа, Сүрэнжавын Лүндэг, Ганбатын Очирбат, Ганзоригийн Тэмүүлэн, Лутаагийн Энхнасан, Жигжидийн Батжаргал, Пүрэвжавын Ганзориг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Чинбатын Номин, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Лувсаннъямын Гантөмөр, Цагаанхүүгийн Мөнхбат, Буяагийн Тулга, Дамдины Цогтбаатар, Дашцэрэнгийн Энхтүвшин, Жамбын Батсуурь, Хассуурийн Ганхуяг, Баатаржавын Мөнхсоёл нарын гишүүд ирсэн байна.

Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөл, Засгийн газар 2026 оны 05 сарын 25-ны өдөр ирүүлсэн зөвшилцөх ийм асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. З.Мэндсайхан Сангийн сайд, Тулга тус яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гантогтох тус яамны Санхүү бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг тус яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Марал тус яамны Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Батлан хамгаалах яамнаас Гансүх тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, Хууль зүй, дотоод

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хэргийн яамнаас Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Отгонбаяр тус яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Эрүүл мэндийн яамнаас Батшугар Эрүүл мэндийн сайд, Эрдэнэбаяр тус яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хүрэлбаатар тус яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Б.Бат-Эрдэнэ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Наранцэцэг тус яамны Соёл, урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга.

Бусад албан тушаалтнуудыг танилцуулъя. Анхтуяа Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батболд Хавдар судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал, Отгонбаатар Эх хүүхэд, эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал, Галбадрах Гэмтэл согог судлалын судлалын үндэсний төвийн захирал, Нарантуяа Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хурандаа, Болор-Эрдэнэ Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч, хурандаа, Энхжаргал Дуурь бүжгийн эрдмийн театрын Захиргааны хэлтсийн дарга эдгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байна.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан сайдыг микрофонд урьж байна. 3 номерын микрофон нээгээрэй.

3.Мэндсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Бүгд Найрамдах Австри Улсын Ерөнхийлөгч Александр Ван дер Беллений 2025 оны 05 дугаар сард хийсэн төрийн айлчлалын үеэр 60 сая еврогийн эх үүсвэртэй санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулах эрмэлзлийн захидлыг хоёр улсын Сангийн яам хооронд байгуулсан.

Хэлэлцээрийн хүрээнд Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох журмын дагуу яамнуудаас санал авч, Эдийн засаг, хөгжлийн яамнаас эдийн засаг, нийгмийн үр өгөөж, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт туссан байдлаар эрэмбэллээ.

Үүний дагуу төслийн жагсаалтыг Австрийн талд хүргүүлэн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дүнг 65 сая евро байхаар тохиролцсон бөгөөд тус эх үүсвэрээр Хавдар судлалын үндэсний төвийн, Гэмтэл согогийн судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр зэрэг 7 байгууллагад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах төсөл хэрэгжүүлэхээр төслүүдийн нэр, дүнг хэлэлцээрийн хавсралтад тусгалаа.

Хэлэлцээрийн хүрээнд ашиглах зээлийн эх үүсвэр нь 1 хувийн хүүтэй, 09 хувийн баталгааны шимтгэлтэй, 19 жилийн хугацаатай, эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй бөгөөд тус хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ болно.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Иймд Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурах, эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайдад баярлалаа.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн гишүүн танилцуулах юм байна. Эдийн засгийн байнгын хороо сая хуралдаад дууссан. Одоо санал, дүгнэлт ирж байгаа юм байна. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг ороод ирэхээр нь та бүхэнд тараагаад хүргүүлчихье.

Тэгээд асуулт хариултдаа орж байя. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Ганбат гишүүнээр тасаллаа. Наранбаяр гишүүн асуулт асууна.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээрээ энэ Австри улстай байгуулж байгаа энэ гэрээ бол нэн хөнгөлөлттэй зээлийн нөхцөлтэй их амжилттай байгуулж байгаа гэрээний ийм төсөл гэж харж байгаа. Үүнийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа юуны түрүүнд илэрхийлье.

Урд талын түүхийг нь сөхөөд үзэх юм бол нэг ийм хэлэлцээр Австри улстай 3 удаа байгуулсан. Нийтдээ бол 16 төсөл хэрэгжсэнээс 10 нь эрүүл мэндийн салбарынх байна лээ. Би хэрвээ андуураагүй бол. Өөрөөр хэлбэл 62 хувь нь.

Гэтэл өнөөдөр ингээд орж ирж байгаа төслийг хавсралтаас нь харахаар 7 төсөл үүний 6 нь эмнэлэг байгаа. 1 нь бол Дуурь бүжгийн дуурийн эрдмийн театрт тоног төхөөрөмж авч өгөх ийм л юм байна лээ. Тэгэхээр яах вэ энэ удаад бол энэ Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам ямар шалгуур эрэмбээр энэ 7 төслийг сонгосон юм бэ гэдгийг 1 дүгээрт асууя. Яагаад нэг салбар луу хэт их хэлбийх болсон бэ? Эрүүл мэндийн салбарт бол хөрөнгө оруулалт хэрэгтэйг маш сайн ойлгож байгаа. Гэхдээ бүх яамдаас саналыг нь авсан атлаа ерөөсөө л 7 төслийн 6 нь эмнэлэг рүү. Энийг 1 дүгээрт тодруулъя.

Боловсролын яамны зүгээс бол аль ноднин жилээс эхлээд л энэ саналаа өгөөд л ерөөсөө энэ мэргэжлийн боловсролыг дэмжье. Өнөөдөр бүх хүүхдүүд их дээд сургуульд ордог биш мэргэжлийн боловсрол төрөлжсөн ахлах сургуульд сурдаг болгоё гээд ингээд яваад байсан. Тэгээд мэргэжлийн боловсролын салбарт бол 7.8 сая еврогоор энэ байж байгаа 30-аад төрийн өмчийн ийм мэргэжлийн боловсролын сургуулиуд байгаа. Тоног төхөөрөмж гэж ийм төсөв дээр бараг тавигддаггүй. Энэ тоног төхөөрөмжийг нь дэмжье гэсэн ийм төслийн саналыг өгч байсан.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Өнөөдөр энэ мэргэжлийн боловсролын салбарт ойролцоогоор 42, 41 мянган залуучууд сурч байна. 10, 10-н мянган хүнээр нэмэгдээд ингээд жил болгон элстэй нэмээд явж байгаа. Монгол Улсын хөгжилд шууд өөрийн гараар улс орноо бүтээх ийм залуучуудыг ингээд бүтээгээд ингээд явж байгаа ийм улсуудыг яагаад энэ төслийг хасчхав? Ямар эрэмбээр та бүхэн хассан юм бэ? Хасагдсан тайлбар шалтгаан юу юм бэ? Судлаад үзэхэд Сангийн яамнаас хассан. Өнөөдөр тэр Тулга дарга сууж байна. Яагаад хассан юм, яагаад хассан юм? Тэгээд тэндээсээ Эдийн засаг, хөгжлийн яам руу бид бас саналыг зөндөө явуулсан. Хасагдсан байдлаар ороод ирсэн байна. Ингэж болохгүй шүү дээ. Нэг юм руу ингээд нэгийг хийхээрээ нөгөөхөө хаядаг. Эрүүл мэнд, боловсрол чинь салшгүй. Тэгэхээр энэ дээр яагаад энэ хассан бэ гэдгээ нэг тайлбарлаадах.

Н.Наранбаатар: Яагаад боловсролын салбар хасагдчихав гэж асууж байна. 2 номер хариулъя. Нэр, албан тушаалаа хэлээд хариулъя.

С.Тулга: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга. Гишүүний асуултад хариулъя. Эрэмбийг бол Сангийн яам тогтоогоогүй байгаа. Эрэмбийг бол бид Сангийн яамны зүгээс ийм хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр байна гээд төсвийн ерөнхийлөн захирагч болгоноос санал аваад ерөнхийлөн захирагчийн ирүүлсэн төслийн саналыг бүгдийг нь нэгтгээд Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслүүдийг эрэмбэлсэн байгаа.

Яагаад эрэмбэлээд ирүүлсэн төслөөс энэ 7 нь багтсан бэ гэхлээр Австрийн талаас дээд тал нь 60 сая еврогийн хөнгөлөлттэй зээл олгох боломжтой гэсэн. Тэгээд Австрийн Сангийн яамтай бид хэд 3 удаагийн зээлийн хэлэлцээр хийсний үндсэн дээр 5 сая евро нэмэгдүүлээд ингээд 65 сая евро болсон байгаа. Одоо тэгээд олгож байгаа хөнгөлөлттэй зээлийнхээ хүрээнд багтаж байгаа төслүүд нь энэ 7 болж орж ирж байгаа юм гишүүн ээ.

Н.Наранбаатар: Тодорхой хариулъя. Гишүүдийн асуусан асуултад. Эрэмбийг нь яаж тогтоосон. Эдийн засаг, хөгжлийн яам эрэмбэ тогтоосон гэххэв үү сая? Эдийн засаг, хөгжлийн яамнаас байна уу? Ажлын хэсэг байхгүй байгаа юм байна. Наранбаяр гишүүн тодруулъя.

П.Наранбаяр: Тэр Сангийн яамны тайлбарыг бол сонслоо. Энийг хариулт гэж хэлэхэд хэцүү. Ингэж хариулж болохгүй шүү дээ. Танай яамнаас Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн 10 төсөл байсан. Ерөөсөө тэн дээр бол 1 ч боловсролын юм байхгүй. Байхгүй. Ингээд хийчихдэг. Тэгэхээр зэрэг ерөөсөө ийм мэргэжлийн боловсролоо дэмжих ёстой гэж ингэж Боловсролын яаманд саналаа өгсөөр байтал 7-гийн 7-н эмнэлэг дэмжинэ гээд ингэж ингэж туйлшруулж бас болохгүй шүү дээ Сангийн яам. Энэ дээр хариултаа яг хэл л дээ. Ямар шалгуур эрэмбээр эхний энэ 10-ыг тэгвэл сонгосон юм? Сангийн яам тодруулж хариулъя. Хэдэн номер вэ? 2 уу? 2 номер.

С.Тулга: Гишүүний асуултад дахиад хариулъя. Сангийн яамнаас төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирсэн бүх саналыг нэгтгээд Эдийн засгийн яаманд хүргүүлсэн. Эдийн засгийн яамнаас төслүүдийг эрэмбэлээд ирсэн. Эрэмбэлж орж ирж байгаа 7 төсөл маань Австрийн талаас олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт багтаж байгаа төслүүд нь энэ 7 учраас ингэж орж ирсэн байгаа гэдгийг дахиад хэлье.

Н.Наранбаатар: Наранбаяр гишүүн тодруулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр Сангийн яам ингээд түлхээд байж болохгүй л дээ. Танайхаас ирсэн 10 төсөл дотор ороогүй байсан. Угаасаа ороогүй байсан. Ямар шалгуураар энийгээ шалгачихсан юм бэ гэдгийг огт тайлбарлахгүй байгаад чинь л би асуугаад байна шүү дээ. Зүгээр Австрийн тал ингээд сонгочихсон юм гээд. Тэгж худлаа ярьж болохгүй шүү дээ. Монгол талын саналыг л үндэслэж тэнд чинь яаж байгаа шүү дээ. Та өөрөө хэллээ 60 сая байсныг 65 болгосон гээд сайн байна.

Тэгэхдээ энэ дээрээ яагаад энэ боловсролын талыг бол огт оруулахгүй хаясан юм бэ? Би түрүүнд хэлсэн шүү дээ хэлсэн үгэндээ 3 удаагийн хэлэлцээрийн хүрээнд 16 төсөл хэлэлцэхэд тухайн хэрэгжүүлэхэд тухайн төслийн 10 нь бол эрүүл мэнд байсан. Гэтэл энэ удаа зөвхөн эрүүл мэнд ороод ирсэн. Ингэж болохгүй шүү дээ. Боловсрол чинь хаачихсан юм бэ, ямар шалгуураар та нар хасчихсан юм бэ гэж би асуугаад байна шүү дээ. Та нар өөрсдөө эхэлж өгөөгүй шүү дээ. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам руу 10 төсөл явуулсан. Тэгээд тэрийгээ Австри болоод Эдийн засгийн хөгжлийн яам руу түлхээд байгааг би гайхаад байна. Энийгээ хариулъя л даа.

Н.Наранбаатар: 2 номер тодруулж хариулъя.

С.Тулга: Наранбаяр гишүүнээ би танд Сангийн яамнаас явсан бичиг болон хавсралтыг нь хэвлээд үзүүлье. Манайх бол ерөнхийлөн захирагчаас ирсэн бүх төслийн жагсаалтыг нь хавсралтаар Эдийн засгийн яаманд хүргүүлсэн байгаа. Тэгээд эрэмбэлээд орж ирсэн юмыг нь л оруулж ирж байгаа.

Н.Наранбаатар: Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Би энэ хэлэлцээрийг дэмжиж байгаа. Тэгээд 2 тодруулах юм байна. Нэгдүгээрх нь энэ хэлэлцээртэй холбоотой энэ дээр 3.2 дээр тусламжийн зээлийн хөнгөлөлтийн түвшин нь хамгийн багадаа 35 хувь байна гэж гэрээн дээр байгаа нөхцөлөө хэлэлцээр хийсний үр дүн 42.81 болгож сайжруулсан юм байна гэж ойлголоо. Тэгэхээр энд хэлэлцээр яаж явдаг тэгээд энийг жишээлбэл 42.81 гэдэг нь өшөө дахиад нэмэх бололцоо боломж байсан юм уу 1 дүгээрт энэ гэрээтэй холбоотой?

Дээр нь баталгааны шинэтгэл 0.9 хувь гэж байна. Энэ нь үлдэгдэл дүнгээсээ тооцоод жишээлбэл 19 жилийн хугацаатай зээл юм байна шүү дээ. Тэгэхээр үлдэгдэл дүнгээсээ тооцоод шимтгэлээ жил болгон төлөөд явдаг юм уу эсвэл 1 удаа төлөөд явдаг дүн мөн үү?

Дараагийн асуулт нь болохоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2 жилийн хөтөлбөр сая хэлэлцэхэд маш ноцтой нэг үзүүлэлт бол нярайн эндэгдэл байсан. Нярайн эндэгдлийн түвшин нэмэгдчихсэн иймэрхүү статистик үзүүлэлт байсан. Тэгээд энэтэй холбоотойгоор бас энэ хэлэлцээрийн хүрээнд нэг төсөл нь болохоор эх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах төсөл гэж байна. Тэгэхээр яг энэ төслийн талаар илүү мэдээлэл өгөөч? Энэ нь түрүүн дурдсан нярайн эндэгдлийг бууруулахад яаж нөлөөлөх ийм төсөл, бууруулахад чиглэсэн төсөл байгаа юу гэдэг талаар мэдээлэл өгөөч? Ийм 2 асуулт.

Н.Наранбаатар: Хариулъя. 2 номерын микрофон.

С.Тулга: Тулга Сангийн яам. Энхтүвшин гишүүний эхний 2 асуултад хариулъя.

Өрийн удирдлагын хуульд заасан хөнгөлөлтийн түвшин гэж байгаа. Энэ хөнгөлөлтийн түвшин бол олон улсын валютын сангаас гаргасан аргачлалын дагуу тооцогддог. Энэ хөнгөлөлтийн түвшин 35-аас дээш гарах юм бол хөнгөлөлттэй гэж тооцогддог байгаа. Энэ зээл маань өөрөө 42 хувийн хөнгөлөлтийн түвшин хангасан учраас хөнгөлөлттэй түвшинд бол нэн хөнгөлөлттэй түвшинд бол орчхоод байгаа юм. Тэр баталгааны хүү бол яг зээл шиг тооцогдоно. Австрийн Засгийн газар буюу Сангийн яамнаас нь Австрийнхаа 2 арилжааны банкаар дамжуулж энэ зээлийг Монгол Улсын Засгийн газарт дамжуулж өгч байгаа учраас энэ 2 арилжааны банк дамжуулсных нь төлөө нөгөө банкнууд дээрээ баталгаа гаргаж байгаа энэ шимтгэл нь ороод явж байгаа. Тийм. Энэ бол яг нөгөө зээлийн ашиглалтаасаа тооцно. Яг хүү шиг.

Н.Наранбаатар: Ганбат гишүүн асуулт асууя. Тодруулах уу? Гүйцээж хариулах уу? 6 номер ажлын хэсгийн хариулъя.

Ж.Отгонбаатар: Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Отгонбаатар байна. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тогтвортой хөгжлийн зорилт дээр болох дээр нярайн эндэгдлийн түвшнийг 12 ба түүнээс доош бууруулах ийм зорилт бол тавьсан байгаа. Энэ Тогтвортой хөгжлийн зорилт нь 5 хүртэлх насны 11 сая хүүхдийг эндэхээс нь сэргийлэх боломжтой байна гэж бол үзсэн байгаа. Дэлхий нийтээр бол 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 47 хувийг нь бол нярайн эндэгдэл эзлээд байгаа. Энэ нярайн эндэгдэлтэй зонхилох шалтгаант нь болох дээр Монгол Улсын хувьд бол дутуу төрөлт 1 дүгээр байранд нь орж байна. 2 дугаарт нь төрөлхийн хөгжлийн гажиг, 3 дугаарт нь төрөх үеийн хүндрэл, 4 дүгээрт нь амьсгалын замын цочмог халдвар, үжил гэсэн ийм үндсэн 5 зүйл эрэмбэлэгдэж байгаа.

Манай Австрийн төсөл дээр болох дээр манай үндэсний төвөөс бол нярайн тусламж, үйлчилгээ бол эрт эмчилгээний тоног төхөөрөмж, ургийн монитор, инкубатор, мөн дүрс оношилгооны аппарат, тоног төхөөрөмж, эхо болон дурангийн ийм захиалгатай байгаа. Эдгээрийг бол төрөлхийн хөгжлийн гажгийн улмаас эндэл бол их байгаа.

2 дугаарт нь дутуу төрөлтөөс шалтгаантай эндэгдэл их байгаа учраас төрөлхийн хөгжлийн гажгийг эрт үед нь оношлох асуудал бол нэн шаардлагатай байгаад байгаа юм. Тухайлбал, 2021 онд бид нар 23.1 хувийг нь бид нар ураг үед нь оношилж чаддаг байсан бол одоо 25 оны байдлаар бол 33.5 хувийг нь оношилж чаддаг болчихоод байгаа. Гэхдээ дээрээс нь бол бид нар энэ тоног төхөөрөмжийнхөө чадлыг бол сайжруулснаар энэний оношилгооны ураг үед нь оношилгоог бол сайжруулах 1 дүгээрт.

2 дугаарт нь ураг үед нь янз бүрийн төрөлхийн хөгжлийн гажиг, оношилсон тохиолдолд бид нар ургийн мэс заслын асуудлыг хийх ийм тоног төхөөрөмжүүдийг эндээ суулгаж захиалсан байгаа гэсэн ийм хариулт өгье өө.

Н.Наранбаатар: Ганбат гишүүн асуулт асууна.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Д.Ганбат: Энэ би ч өөрөө Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн л дээ. Тэгээд Төсвийн байнгын хороо ингээд хамтарч хуралдаад байгаа нь бас их олзуурхмаар юм уу гэж бодоод байна. Энэ манай төсөв чинь аюулгүй байдлынхаа хэмжээнд оччихсон юм биш үү ер нь? Зориуд ингэж хийж байна уу, эсвэл санамсаргүй маягаар ингээд бас нөгөө ажлын төлөвлөгөөнд ороод ингэж явж байгаа уу гэдгээ мэдэхгүй байна. Гэхдээ уул нь бол Монгол Улсын энэ авч байгаа татвар энэ юм хумаа улсын төсвийг хараад байхад бол гадна, дотноос янз бүрийн тэр зээл авалгүйгээр шийдчихмээр байх юм. Тэгээд нэн хөнгөлөлттэй зээл гэдгийг л бүх зээлүүддээ л ярьдаг л даа. Тэгээд улсын төсөв чинь 2, 3 болчихсон уу энэ зээллэг мээллэг чинь? Саяхан л нөгөө нефть боловсруулах үйлдвэр, өшөө Эрдэнэбүрэний цахилгаан станц 2-ыг тусад нь гаргаад л тавьчихна лээ. Ингээд яваад байхаар тэгээд болж байгаа юм уу даа? Одоо Монгол Улсын Засгийн газрын зээл ямар хэмжээнд байна вэ? Жилд хэдийг төлөөд байна вэ? Монгол Улсын өр төлбөр хэд байгаа? Яах вэ зарим манай гишүүд ярьдаг л даа. Бид нар авч л байдаг. Дараа үе нь төлөх л төлөөд дуусвал дуусна л гэж гэсэн юм ярьдаг. Тийм биш л дээ. Өртэй хүн өөдөлдөггүй л дээ. Тэр байтугай энэ улс орны зэрэглэлээр бол тэр хамгийн өрийн хавханд орж болзошгүй 5 орны 1-ээр бол Монгол Улс тодорчихсон байна гээд л гараад байх юм.

Тэгээд энэ төсвийн алдагдал чинь бол хэрээс хэтэрч байна шүү дээ. Энэ мэнийгээ хаанаас юугаар санхүүжүүлж байгаа юм? 2 аргаар л санхүүжүүлдэг байх л даа. Нэг нь бол зээллэгээр, нөгөөдөх нь бол мөнгө хэвлэхээр. Энэ ханш бол яваад өглөө. Энэ махны үнэ энэ тэрийг харж байхад. Ер нь тэгээд энэ зээл авахгүйгээр шийдэж болдог юм уу болдоггүй юм уу? Ийм их улсын төсөв чинь 3-хан жилийн өмнө 11 их наядыг батлаад л байж байсан. Өнөөдөр 34, 3 их наядыг батлаад л ингээд л явж байна. Тэгээд энэ чинь тэгээд зөв арга зам юм уу ямар байгаа юм? Зээлжих зэрэглэл чинь арай гэж 11 жилийн өмнө ямар байлаа тэрэндээ л нэг өнгөрсөн жил очих шиг болно лээ. Тэгээд энэ байдал чинь бол нэг их сайхан санагдахгүй л байна л даа. Тэгээд энэ тоо баримтуудыг бол би бол мэдэж л байна. Гэхдээ та нар бас ахиад нэг хэлчхээрэй. Нэг ийм ийм өр авлагатай, Засгийн газар энэ зээлээ ингэж ингэж төлж байгаа гээд тэгээд улсын төсөв чинь бараг хэдэн хувь нь байна 3 хувь нь байна уу 5 хувь, 5 хувь нь ч байна уу ингэж явж байгаа байх гэж ойлгож байна. Тэгээд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ тэр юм нь оновчтой байна уу үгүй юу? Энэ гадуур бол бэлгийн замын халдварт өвчин энэ тэр бол найгүй болчихсон байна шүү дээ.

Н.Наранбаатар: Сүүлд Дэгийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр энэ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар олон улс улсын гэрээний төсөл, эсвэл эх бичвэр холбогдох баримт бичгийг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн хэлэлцэнэ гэсэн байгаа. Гишүүний асуултад сайд хариулъя. 3 номер.

З.Мэндсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Засгийн газрын нийт өр 35.8 их наяд байгаа. Тэгэхээр бид нар Өрийн удирдлагын тухай хуулиараа ДНБ-ий 60 хувь хүртэл зээл авч болно гадаад зээл. Тэгэхээр одоогийн энэ 35.8 бол ДНБ-ий 35.9 хувийг эзэлж байгаа. Жилдээ бид нар нийтдээ хүү болон үндсэн төлбөрт 2.7 их наядыг төлж байгаа. Энэнээс хүү нь 1.2, үндсэн төлбөр нь 1.5 их наядыг төлж байна.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ер нь бол манай улс орлогын түвшнээсээ хамаараад нэн хөнгөлөлттэй зээлийн ангиллаас гарч байгаа. Тэгэхээр энэ бол бид нарт магадгүй Монгол Улсын Засгийн газарт олдож байгаа байх нэн хөнгөлөлттэй зээлүүдийн бараг сүүлчийнх нь байх гэж бодож байна. Цаашдаа бид нар арилжааны хүүтэй зээл аваад явна.

Н.Наранбаатар: Би нэг асуулт. Энэ эрүүл мэндийн салбарт түлхүү энэ удаагийн зээл явах. Юм байна. өмнөх 3 удаагийн хэлэлцээрээр 120 сая еврогийн зээл бас эрүүл мэндийн салбар руу голлоод явсан. Тэгэхээр энэ өндөр технологийн тоног төхөөрөмжүүдийг аваад ашиглах тийм боловсон хүчин, мэргэжилтнүүд нь бэлэн байгаа юм уу яг өнөөдрийн байдлаар? Өмнөх авсан энэ том үнэтэй өндөр технологийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, урсгал зардлын асуудал ямар байгаа юм бэ гэдэг дээр нэг хариулт өгөөч.

5 номер ажлын хэсгийн. Хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр. Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид нар энэ өмнө нь 74.5 сая еврогийн зээл хэрэгжсэн байгаа. Түрүүн Наранбаяр гишүүний хэлснээр яг 10 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн. Энэ дээр бид нар бас тодорхой хэмжээний үнэлгээнүүд хийгдсэн. Аливаа энэ гаднын зээлээр хэрэгжиж байгаа энэ төслүүдийн хүрэн дээр бол заавал энэ дээр дагалдсан сургалтууд явдаг. Тэгэхээр энэ сургалтууд бол бүгд ингэж төслийн яг бичиг баримт дээр заагдаж явдаг учраас энэ дээр бид нар хүний нөөцөө бас бэлтгэх, энэ шинээр нэвтрүүлж байгаа техник технологиудыг нутагшуулах чиглэл дээрээ бол бас онцгой анхаарч ажилладаг байж байгаа.

Ер нь салбарын хэмжээний тоног төхөөрөмжийн ашиглалтыг аваад үзвэл энэ дээр бас нэг зарим хангалтгүй үзүүлэлтүүд байгаа. Тухайлбал, бид нар орон нутгийн түвшин дээр гэдэг юм уу яг тухайн хүн амын үйлчлэх хүрэнээс давсан ийм одоо үзүүлэлттэй тоног төхөөрөмжүүд байгаа. Тэр ашиглалтын хувь нь өөрөө бас бага хувьтай байдаг. Тухайлбал, бид нар зүгээр энэ дүрслэл, оношилгооны гээд бас энэ тоног төхөөрөмжүүд байдаг бас өртөг өндөртэй СТ, MRI гэсэн тоног төхөөрөмжүүд байдаг. Энэний ашиглалтуудыг ингээд бас хяналт үнэлгээ, шинжилгээ хийж үзэхэд тухайлбал бид нар энийг 25-156 хувь гэсэн ийм ашиглалтын ийм ялгаатай байдал бий болж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр шинэчлэн батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль дээр энэ тоног төхөөрөмжийн бодлогын асуудлуудыг бол манай Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар дээр бас энэ бодлогуудыг гаргах энэ ажлууд бол ингээд хуулийн шинэчилсэн найруулга хийгдсэнээс хойш бол явагдаж байна. Энэ дээр бид нар бас тодорхой хэмжээний журмуудыг хийж, эрүүл мэндийн салбарт одоо ялангуяа энэ хэрэглэгдэж байгаа, захиалж байгаа, шинээр авч байгаа энэ тоног төхөөрөмжүүдийн бүртгэлийг 1 дүгээрт нь хийх асуудлууд байж байгаа.

2 дугаарт нь хэрэгцээ шаардлагуудыг илүү бас гаргаж ирэх энэ хэрэгцээ шаардлагууд бас байгаа. Ер нь зүгээр бид нар энэ дээр яг өнөөдрийн явж байгаа түвшин дээрээ аваад үзвэл бас ийм хангалтгүй үзүүлэлтүүд бас байгаад байгаа юм. Тухайлбал, бид нар түрүүн хэлээд байгаа тэр сумын түвшин дээр гэдэг юм уу

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

яг одоо 4D эхо ч гэдэг юм уу ийм өндөр түвшний ийм тоног төхөөрөмжүүдийг суурилуулаад өгчихөөр энэ дээрээ яг ажиллах хүний нөөцийн асуудлууд бас тулгамддаг. Тэгэхээр бид нар энийг цогцоор нь тухайн тоног төхөөрөмж гэдэг байдлаа энийг хүний нөөцтэй хамт бэлтгэдэг байдлаар явж байгаа.

Энэ удаагийн энэ зээлийн хүрээн дээр бол энэ манай яг голлох төв эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлийн ийм 4 эмнэлэг яг орсон байж байгаа. Тэгэхээр энэ эмнэлгүүдийн хувьд бол өмнө нь бас хийдэггүй байсан энэ технологиудыг 1 дүгээрт нутагшуулах гэдэг чиглэлээрээ ажиллаж байгаа.

2 дугаарт нь бид нар бас энэ дээр эрүүл мэндийн салбар дээр бас энэ шинэ технологиудыг нэвтрүүлснээр хөрш 2 орноос бас энэ ойролцоо байдаг энэ бүс нутгийн иргэдийг бас Монгол Улсад зарим нэг эмчилгээнүүдийг хийх, ялангуяа эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал гэдэг юм уу, энэ хавдрын мэс заслуудыг бас Монгол Улс руу эргэж валют татах гэдэг энэ үндэслэлүүдээр бас ер нь бол энэ төслийн санаанууд дээр оруулж ирсэн.

Өөрөөр хэлбэл, энэ бол бас олон улсад нэлээн бас өндөр хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн энэ технологиудыг Монгол Улсад нэвтрүүлэх.../минут дуусав./

Н.Наранбаатар: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Наранбаяр гишүүн үг хэлнэ.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр бид бас энэ Австри улсаас бол ийм хөнгөлөлттэй, нэн хөнгөлөлттэй ийм нөхцөлөөр түрүүнд бас хэлж байна Монгол Улс хамгийн сүүлд авч байгаа гэдэг юм энэнээс цааш бол ийм нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл бараг олдохгүй болов уу гэдгийг бол би бүрэн хуваалцаж байна. Тэр утгаараа бол Сангийн яам бас энэ зээлийн төслийг Австри талтай бол нэлээн амжилттай хэлэлцлээ гэдгийг бол би энэ талаас нь бол үнэлж байгаагаа хэлье.

2 дугаарт энэ эрэмбийн асуудал дээр бол яахын аргагүй энэ дээр эргэж харах юм байна. Эдийн засаг, хөгжлийн яам энд ирэхгүй юм байна тиймээ, ажлын хэсэгт байхгүй гээд ирэхгүй юм уу? Тэгэхээр энэ Эдийн засаг, хөгжлийн яам дээр ингээд ирсэн энэ Сангийн яамнаас ирүүлсэн 10 төслийг эрэмбэлэхдээ яаж эрэмбэлсэн, ямар шалгуураар байгааг бичгээр энэ авмаар байна. Чухам ямар шалгуураар энийг шалгаад авчихсан юм бэ? Яагаад мэргэжлийн боловсролын асуудал ингээд орхигдчихов? Улс орны хувьд бол эрүүл мэнд, боловсрол бол салшгүй холбоотой ийм асуудлууд.

Тэгэхээр ийм бид бол ингээд өнөөдөр энийг батлах юм бол яах вэ зарчмын хувьд дэмжиж байна. Гэхдээ ингээд 7-хон төсөл байгаагийн 6 нь шууд эмнэлэг дээр л очиж байгаа. 1 нь дуурь руу явж байгаа. Ийм байдлаар бас бид төслүүдийг бас хэрэглээд байж болмооргүй байна. Ер нь бол бас энэ бусад салбар, ялангуяа боловсролын салбарыг анхаарах нь зүйтэй. Энэ утгаараа хэлж байгаа шүү. Ялангуяа мэргэжлийн боловсролын салбар. Энэ бол өнөөдөр 40 гаран мянган хүн сурч байна. Тэгээд тэндээсээ бас энэ улс орондоо хэрэгтэй, хамгийн хэрэгтэй байгалийн ухаан, инженерийн ухаан, янз янзын энэ сантехник энээ тэрээ гээд ийм

гартаа өөрийн гэсэн чадвартай ийм хүмүүсийг л төгсгөж байгаа ийм чухал салбар шүү дээ.

Ийшийгээ тоног төхөөрөмж нийлүүлэх, ийшийгээ бас хөгжлийг нь дэмжих гэдэг бол туйлын чухал байгаад байгаа. Тэгэхээр энэ утгаараа бас эрэмбэлэлтийн энэ шалгууруудыг яаж тавихаараа зөвхөн нэг салбар руу тавьчихдаг юм гэдгийг бас гайхаж байгаагаа хэлье. Тэгэхээр энэ дээр хэрвээ боломжтой бол бас энэ Эдийн засаг, хөгжлийн яам 1 дүгээрт энэ юугаа эргэж харах хэрэгтэй. Энэ дээр бас ганц нэг жоохон мэдээж энэ 65 саяыг орвонгоор нь эргүүлнэ гэж байхгүй шүү дээ. Энэ дээр бол энэ жилдээ 27 ондоо жишээлбэл байр сав нь бэлэн бус байх ийм төсөв, төсөл байх юм бол тэн дээрээ бас өөрчлөлт хийж оруулах ийм шаардлагатай гэж харж байна.

Тэгэхээр энэ дээр ийм саналтай байгаагаа 1 дүгээрт бас хэлмээр байна. Тэгэхээр Сангийн яамнаас бол энэ 10 төслийг би сая харлаа. 10 төслийн 9 дээр нь Боловсролын яамны бас саналыг бол оруулсан байсан юм байна. Тэрийгээ бол би бас засварлаж хэлье. Гэхдээ ингэж эрэмбэ, шалгуурыг тавихдаа ийм байдлаар шалгаруулсан явдал бол бас сонирхолтой санагдаж байна. Ийм учраас энэ дээр бас Эдийн засаг, хөгжлийн яамнаас нарийн тайлбараа ирүүлэх ёстой гэдгийг хэлье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Эдийн засаг, хөгжлийн яамнаас бичгээр Наранбаяр гишүүнд эрэмбийн асуудлыг хүргүүлэх нь байна. Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Энэ асуудлыг хойшлуулах саналтай байна. Яагаад гэвэл Сангийн сайдаас бусад сайд нар ирээгүй байна шүү дээ. Тэгээд Байнгын хороонд энэ том бараг 200 гаруй тэрбум төгрөгийн үнийн дүнтэй зээлийн хэлэлцээрийг танилцуулахад ингэж хандаж байгааг бол миний хувьд бол Их Хурлын гишүүний хувьд бол хүлээн зөвшөөрөхгүй байна. Эдийн засаг, хөгжлийн яам эрэмбэлнэ гэж байна. Тэгээд яг яаж эрэмбэлээд байгаа юм бэ? Энэ Эдийн засгийн яам байгуулагдсанаар эдийн засаг сайжрах, эрэмбэ зөв тогтоох үүрэгтэй л яам биз дээ энэ чинь. Тэгээд ингээд хараад байхад ерөөсөө ийм юм байхгүй байгаад байна. Сангийн яам бол төлөвлөлт хийдэг байгууллага биш шүү дээ. Тэгэхээр Эдийн засгийн яам энэ дээр бол гол үүрэгтэй оролцох ёстой.

Ер нь бол ингээд энэ зээл гэдгийг чинь зүгээр аваагүй шүү дээ, Буцаагаад төлнө. Тэгээд зүгээр өгч байгаа юм шиг л ингээд л нэг авдаг, тэгээд эрэмбээ зөв тогтоодоггүй. Тийм учраас энийг бол энэ удаа бол хойшлуулах нь зөв өө. Сайн нягталж байж, Эдийн засгийн яам нь тайлбараа хэлж, бусад салбарын сайдаар нь тайлбараа хэлж явахгүй бол салбарын сайд чинь төсвийн ерөнхийлөн захирагч биз дээ? Тэгээд хэдэн Төрийн нарийн бичгийн даргаа явуулчихаад л. Тэгээд өнөөдөр чинь Засгийн газрын хурал үдийн өмнө болсон. Үдээс хойш тэгээд энд Байнгын хороонд оролцох ёстой шүү дээ. Тэгээд энэ ер нь энэ томоохон зээлээр авч байгаа төслүүдийг бол цогцоор нь шийдэх ёстой. Байнгын хорооны гишүүдтэй би санал нэг байгаа.

Хүний нөөцөө бэлдэх ёстой. Ашиглалтын зардлыг нь яах юм? Тэгэхгүй тэгээд ингээд нэг гашуун туршлага байгаа шүү дээ. 2 зэргэлдээ аймагт 1 аймагт нь эхо аппарат биш ээ, СТ томографи аппарат авчихсан. Тэгсэн тэр аймагт нь ажиллуулах эмч байхгүй. Зэргэлдээ нөгөө аймагт нь эмч нь байгаад байдаг. СТ аппарат байхгүй. Тэгээд би энийг бол энэ хуваарилалтыг нь бол тийм оновчтой

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаа гэдэгт бол би бол эргэлзэж байна. Яг хаана хаана яаж хуваарилах гээд ямар үр дүн гарах гээд байгаа юм? Ер нь бол эрүүл мэндийг хамгаална гэдэг чинь урьдчилан сэргийлэх ажил вакцин, анхан шатны оношилгоо, оношлуур. Түүнээс биш ингээд өвдсөн хойно нэг их олон тоног төхөөрөмж аваад л орчин үеийн тоног төхөөрөмж авна нөгөө л хонх нь дуугарахаар дамар нь таг гэдэг шиг хоёулаа дуугарахаар лам нь таг гэдэг шиг. Тэгээд аягүй бол ажиллуулах эмч нь байгаа юм уу, байхгүй юм уу?

Зүй нь бол энэ төслийн хүрээнд эмч нарыг нарийн мэргэжлээр гадаадад дунд, богино хугацаагаар сурах ёстой. Хамгийн багадаа 3 сараас дээш хугацаагаар. Тэгж байж энэ аппараттай чинь ажиллаж сурна. Орчин үед ямар дэвшилтэт технологи олон улсад хэрэгжиж байгаа юм гэдгийг мэдэж ирнэ. Тэгээд энийг цогцоор нь шийдэх ёстой. Зөвхөн аппарат авснаараа асуудал бол шийдэгдэхгүй шүү гэдгийг би бас зориуд онцолж хэлье.

Тэгээд энэ эмч нар дээр гэхэд ингээд ийм механик ажиллагааг нь бууруулах ажлыг сайн хийх хэрэгтэй. Тэр доктор, профессор хүн гэдэг чинь олон 10 жилийн туршид мэдлэг хуримтлуулж тэр зөвхөн шийдвэр гаргадаг хүн байдаг. Манайд харамсалтай нь механик ажлаар дардаг. Тэр эмч оношилгоо, шинжилгээг үзээд хамгийн зөв эмчилгээний тактик, шийдвэрээ гаргадаг хүнийг бид нар хайрлаж, тэрийг бэлтгэж явах ёстой болохоос биш эмчээрээ хамаг механик ажил хийлгээд л эмч нь хамаг стори юмыг нь бичдэг механик ажил байдаг. Энэнээсээ эрүүл мэндийн салбарын шинэчлэл, өөрчлөлт, энэ зээлийн зориулалт бол хэрэгжинэ.

Түүнээс биш ингээд баахан тоног төхөөрөмж авснаараа асуудал бол шийдэгдэхгүй. Өвдсөн хойно нь тоног төхөөрөмж аваад биш өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх ажил дээрээ төсөв, олон улсын энэ зээл, тусламж, байгууллагын дотоод нөөц, бололцоо бүх юмыг ингэж цогцоор нь шийдэж байж үр дүн гарна. Тэгэхгүй бол олон жил тоног төхөөрөмж зээлээр авлаа шүү дээ. Ямар үр дүн гарсан. Тийм учраас.../минут дуусав./

Н.Наранбаатар: Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ.

Л.Мөнхбаясгалан: Энэ санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газарт байж байгаа. Энийг би дэмжиж байгаа гишүүдийн нэг байна. Учир нь өмнө нь Хавдар судлалын үндэсний төв эмнэлэг дээр Австрийн Засгийн газрын 7 сая еврогийн тоног төхөөрөмж авч тавьж хэрэгжүүлсэн. Энэ бол үнэхээр гайхамшигтай үр дүнгээ өгсөн. Манай 3 дугаар шатлалын эмнэлгүүд ялангуяа эмч нар нь бол маш сайн боловсорсон байдаг. Байнга сургалтад хамрагдаж байдаг. Тоног төхөөрөмжийн дутагдалтай байдаг. Би бол энэ эрүүл мэндийн салбарт орж байгаа энэ хөрөнгө оруулалт, энэ хэлэлцээрийг бол маш сайн гэж бодож байгаа.

Яагаад гэвэл энэ хүний амь авардаг байхгүй юу даа. Хэд хэдэн төсөл дээр би Хавдар судлалын үндэсний төвтэй хамтарч ажиллаж байсан. Элэг шилжүүлэн суулгасан. Одоо бөөр шилжүүлэн суулгасан байгаа. Энэ мэтчилэн бодит яг оносон газраа бол их зөв хөрөнгө оруулалт болдог шүү. Энийг бас манай гишүүд харгалзаж үзээд дэмжээсэй гэж би бол уриалж байна.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Н.Наранбаатар: Гишүүд санал хураалттай учраас танхимд орж ирээрэй. Санал хураалт явагдах гэж байна. Санал, дүгнэлтийг Очирбат гишүүн байна уу? Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг уншъя. Уншиж танилцуулъя.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газрын хооронд “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг 2026 оны 05 сарын 25-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 06 сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Тус хэлэлцээрийн төслийн хүрээнд 19 жилийн хугацаанд эргэн төлөх хугацаатай эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй 1 хувийн хүүтэй 0.9 хувийн баталгааны шимтгэлтэйгээр 65 сая еврогийн зээл авах бөгөөд хүүгийн төлбөрт 12.8 сая евро төлнө өө.

Хэлэлцээрийн хүрээнд улсын эмнэлгүүд болон Дуурь бүжгийн эрдмийн театрын тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцад тус төслүүд хэрэгжсэнээр хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан ямар шалгуур үзүүлэлтүүдэд нийцэх талаар болон хэлэлцээрээр хэрэгжүүлэхээр тусгасан төслүүдийг эрэмбэлсэн шалгуур үзүүлэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх төслүүдийн хэрэгцээ шаардлага, хуваарилалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат улсын эмнэлгүүдэд төсөл хэрэгжсэнээр эрүүл мэндийн салбарт гарах үр дүн, ач холбогдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан төслийн хүрээнд эх, хүүхэд, нярайн эндэгдэл бууруулах арга хэмжээний талаар болон Дуурь бүжгийн эрдмийн театрын тоног төхөөрөмжийн шинэчлэлийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан бөгөөд хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 72.7 хувийн саналаар зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газрын хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж өгнө үү.

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Анхаарал хандуулсанд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны дарга Заяабал.

Эдийн засгийн байнгын хороо 72.7 хувиар дэмжсэн ийм санал, дүгнэлт ирүүлсэн байна.

Санал хураалт гишүүд орж ирээрэй. Санал хураалтдаа бэлдье гишүүд. Лүндэг гишүүн санал хураалтдаа бэлдээгүй байна. Бэлдээрэй очиж хэлэхгүй бол. Жаргалан гишүүн ингэх юм байна. Санал хураалтад Жаргалан гишүүнээ. Анар гишүүн бас санал хураалтад бэлтгэе. Аубакир гишүүн бас санал хураалтад бэлдэнэ. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд анхааралтай. Одоо ирцийн санал хураалт явуулаадахъя. Санал хураалт. Тулга гишүүн. Сая сая ирцэд орсонгүй Тулга гишүүн. Гишүүд санал хураалтдаа бэлдсэн биз? Санал хураалт явуулна. Алтанхуяг гишүүн санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт явуулж эхэлье.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт явж дууслаа.

56.3 хувиар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хороо энд хуралтай. Төсвийн байнгын хорооны гишүүд энд үлдээд ирцдээ оръё. Ирц үүсгээрэй. Санал хураалтын дүнг танилцуулъя. Нийт 32 гишүүнээс 18 гишүүн дэмжиж, 56.3 хувиар уг асуудал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хороодын хамтарсан хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

16.01 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ